



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2002 оны 7 сарын 08 өдөр

Дугаар 311

Улаанбаатар хот

ЗАХИРАМЖИНД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоолын 3, 2000 оны 185 дугаар тогтоолын 5 дугаар заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай тохиролцсоны үндсэн дээр ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Нийслэлийн Засаг даргын 2000 оны "Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" 423 дугаар захирамжийн хоёрдугаар заалт дахь Санхүү, эдийн засгийн хэлтэс гэснийг "Төрийн сангийн хэлтэс" гэж өөрчилж, батлагдсан орон тоонд багтаан зохион байгуулсугай.
2. Бүтцийн өөрчлөлт оруулсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн хэлтсийн ажлын байрны үлгэрчилсэн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2000 оны 423 дугаар захирамжийн хавсралтын 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

0201054



Нийслэлийн Засаг даргын 2002 оны  
311.../р... захирамжийн хавсралт

Хоёр. Төрийн сангийн хэлтэс

- 1. Хэлтсийн дарга
- 2. Ерөнхий нягтлан бодогч
- 3. Төсвийн мэргэжилтэн
- 4. Төлөвлөгч эдийн засагч
- 5. Бүртгэлийн мэргэжилтэн
- 6. Орлогын эдийн засагч
- 7. Нягтлан бодогч /Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт 3,  
Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, налайх дүүрэгт 2,  
Багануур, Багахангай дүүрэгт 1/